

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

---

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** САГ-2019/87/СТА-ТӨҮГ

## Агуулга

Агуулга .....	1
1. Аудитын гэрчилгээ .....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил .....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин .....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар .....	6
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..	9
2.11. Шилэн дансны мэдээлэл.....	10
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	10
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	14
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	14
4.2 Аудит хийсэн орлого үр дүнгийн тайлан .....	15
4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	16
4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	17
4.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл .....	18
5 Хавсралт.....	19
5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл.....	19

## Товчилсон үгийн жагсаалт

ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын газар
ТБОНӨХБАУХАТХ	Төрийн Болон Орон Нутгийн Өмчийн Хөрөнгөөр Бараа Ажил Үйлчилгээ Худалдан Авах Тухай хууль
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ  
ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ц.ЭРДЭНЭБЯАР  
ТАНАА

2019.03.20 № 06/538  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1,15.2, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайлан материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудитын тайлан

### 2.1. Оршил

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүн, дүгнэлтийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Эрдэнэбаяр Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, худалдан авалт болон гэрээний биелэлттэй холбоотой 4 зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 2 дугаар сарын 18-наас 2019 оны 3 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Мэжик консалтинг Аудит ХХК-ийн аудитын менежер Г.Мөнхбаяр, аудитор Ц.Гүнсэнмаа, Б.Ананд, аудиторовын туслах Д.Наранбат нар хариуцаж хэрэгжүүлэв.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2018 оны санхүүгийн тайлангаа Мэжик консалтинг Аудит ХХК-д 2019 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн 01/325 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС, НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь “Мэдээлэл, харилцаа холбооны технологийн дэвшлийг Монгол хүн бүрт дамжуулан хүргэж, улс орныхоо нийгэм, эдийн засгийн бүхий л салбарт тогтвортой хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх өндөр хурдны хамгийн хүртээмжтэй үндэсний сүлжээ болно” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажиллажээ.

Холбооны сүлжээний төрийн өмчит компани байгуулах тухай Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 186 дугаар тогтоолын дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үйл ажиллагааны чиглэлийг “Суурь болон салбар сүлжээний кабель шугам, тоног төхөөрөмж, барилга байгууламжийг түшиглэн зөвхөн сүлжээний үйлчилгээ явуулах” гэж тодорхойлжээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн удирдлага Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль



- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Харилцаа холбооны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үндсэн үйл ажиллагааг зохицуулж байгаа эрх зүйн орчны томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагааг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Юникус” програм хангамж ашигладаг байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 22 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрт хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгов.

Материаллаг байдлын түвшинг төлөвлөлтийн үе шатанд 300.7 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөлт ороогүй.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 8 чиглэлээр аудитын 22 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 6 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцохоор шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

/сая төгрөгөөр/				
№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	72.6	
2	Албан шаардлага өгсөн	1	131.8	
3	Төлбөрийн акт тогтоосон	1	0.5	
	Дүн	6	204.9	

### 2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

#### 2.8.1.1 Балансын данстай холбоотой асуудал

Тайлант оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор 0.1 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө дутагдсан бөгөөд тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, эд хариуцагчаар дутагдсан хөрөнгийг төлүүлээгүй, холбогдох арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.1-д “Өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах” заасантай нийцэхгүй байна.



Шийдвэрлэсэн нь: Тооллогоор дутагдсан хөрөнгийг төлүүлэх, 0.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоох

### **2.8.1.2 Зардлын данстай холбоотой асуудал**

Хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллаж байсан гурван ажилтны цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын тайланд орхигдуулснаас Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2018 оны 0455 тоот “Шимтгэлийг нөхөн төлүүлж алданги ногдуулах тухай” улсын байцаагчийн актын дагуу 0.4 сая төгрөгийн алданги тооцож, актын төлбөрийг 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иас барагдуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.7-д ерөнхий нягтлан бодогч нь “аж ахуйн нэгж, байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах”, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1-д “1/хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх; 2/шимтгэл оногдуулах, төлөхтэй холбогдсон мэдээ, тайланг тогтоосон хугацаанд гаргаж даатгалын байгууллагад ирүүлэх; 3/нийгмийн даатгалын холбогдолтой анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журмын дагуу хөтөлж, тайлан тэнцэл гаргах; 4/нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд уг зөрчлийг арилгах талаар эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн 0.4 сая төгрөгийн алдангийг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоох.

### **2.8.1.3 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн худалдан авалт болон гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгаж үзэхэд шууд гэрээ байгуулсан дараах зөрчлүүд илэрсэн байна.

Тухайлбал:

- Ихэр түрүү ХХК-тай байгуулсан сургалтын төвийн тохижилт үйлчилгээний ажил гүйцэтгүүлэх 77.7 сая төгрөгийн гэрээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулаагүй
- Мэгүүн медиа ХХК-тай 32.4 сая төгрөгийн ажил гүйцэтгүүлэх гэрээг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулалт явуулаагүй
- Арбэл алтай ХХК болон Хатанбаатар ХХК-тай нийт 21.7 сая төгрөгийн зураг төсвийн гэрээг зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах журмын дагуу сонгон шалгаруулалт явуулаагүй байна.

Энэ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.1-д заасан босго үнээс хэтрээгүй тохиолдолд харьцуулалтын аргыг хэрэглэж болно” гэж заалт болон Монгол Улсын Засгийн Газрын 2013 оны 68 дугаар тогтоолоор батласан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийг тус тус дагаж мөрдөөгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагаа зохион байгуулахдаа холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулж байх талаар албан шаардлага хүргүүлэх.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Эксперт линк ХХК-ийн гүйцэтгэсэн ажлын гэрээ 2014 онд хийгдсэн бөгөөд одоогийн байдлаар 70 хувийн гүйцэтгэлтэй байгаа. Ажлын гүйцэтгэлийг зогсоох тухай Үндэсний аюулгүй байдлын зөвлөл болон Тагнуулын ерөнхий газраас Эрчим хүчний яаманд албан бичиг, албан шаардлага ирсэн. Үүнд үндэслэн Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ ХХК-иас Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-д албан бичиг ирсэнтэй холбоотойгоор уг ажил зогсонги байдалд орсон байна.

Мөн Монголын цахилгаан холбоо ХХК-тай маргаантай байгаа байр талбайн түрээсийн гэрээг шинэчлэх эсэх, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Монголын цахилгаан холбоо ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иудын хамтарсан ажлын хэсгийн шийдвэрийг дараагийн аудитаар анхаарч үзэх шаардлагатай байна.

## **2.10. Үйл ажиллагааны орлого, зардлын төсөв, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 684 дүгээр тогтоолоор Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны “Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө”-г баталсан байна.

### Орлогын гүйцэтгэл:

Үндсэн сүлжээний борлуулалтын орлого 40,007.6 сая төгрөг, бусад үйл ажиллагааны бус орлого 818.0 сая төгрөг, нийт 2018 оны орлогын дэлгэрэнгүй тайлангаар 40,825.6 сая төгрөгийн орлоготой ажиллаж, гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувиар буюу 5,360.2 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 0.4 хувиар буюу 574.2 сая төгрөгөөр тус тус өссөн байна.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2017 оноос эхлэн үүрэн телефоны оператор Юнител ХХК, Скайтел ХХК, Жи-мобайл ХХК-иудтай техникийн гэмтэл засварын ажил гүйцэтгэх аутсорсингийн гэрээ байгуулж ажиллаж байгаа бөгөөд 2018 онд Мобиком корпорацитай аутсорсингийн үйлчилгээний гэрээ байгуулсантай холбоотой орлого өссөн байна. Мөн сүлжээний өргөтгөлийн бүтээн байгуулалтын ажлуудыг 2018 онд хүлээн авснаар сүлжээний урсгал нэмэгдэж оператор компаниудад нийлүүлэх сувгийн түрээсийн үйлчилгээний орлого өссөн байна.

### Зардлын гүйцэтгэл:

Тайлант оны гүйцэтгэлээрх нийт зардал 37,914.1 сая төгрөг үүнээс удирдлагын зардал 858.7 сая төгрөг байна. Зардлын гүйцэтгэлийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 15.0 хувь буюу 5,006.2 сая төгрөгөөр, төлөвлөгөөтэй харьцуулахад 0.7 хувь буюу 279.8 сая төгрөгөөр тус тус өссөн байна. Зардлын өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлүүд нь аутсорсингийн үйлчилгээ үзүүлж оператор компаниудын орон нутгийн сайтуудад төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх үзлэг үйлчилгээг үзүүлдэг болсон, мөн сүлжээний өргөтгөл, урсгал нэмсэнтэй холбоотойгоор гадаад урсгалын төлбөр нэмэгдсэн байна.

### Эзний өмчийн бусад хэсэг:

Тайлант онд эзний өмчийн бусад хэсэг данс 39,857.1 сая төгрөгөөр өссөн байна. Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд нь Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалаар батлагдсан аргачлалын дагуу дахин үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд уг аргачлалд зааснаар газар өмчлөх эрхийн үнэлгээний нэмэгдлийг эзний өмчийн бусад хэсэгт тайлагнахаар заасантай холбоотой өссөн байна.

### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газраас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн аудит хийгдсэн байна. Уг аудитын үр дүнтэй танилцахад хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээллүүдийг 2018 оны 1,8,10 дугаар саруудад хугацаа хоцорч байршуулсан талаар дурдсан байна.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 502.6 сая төгрөгийн 5 зөвлөмж, 26.9 сая төгрөгийн 2 албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай хэрэгжүүлсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийхдээ АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайлан болон бусад илчлэл тодруулгад тусгасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдийг холбогдох хууль, стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. Менежментийн захидал**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидал АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтэд үндэслэсэн болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

##### **3.1.1 Илрүүлэлт:**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Архангай болон Хөвсгөл аймгуудын салбарт дараах зөрчил илэрлээ:

- Хөрөнгө данснаас хасах, актлахтай холбоотой баримтжуулалт хийгдээгүй 12.9 сая төгрөгийн зөрчил,
- Анхан шатны баримтжуулалтад гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулаагүй болон НБББББ-ийг баримтлаагүй 8.0 сая төгрөгийн зөрчлүүд байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5-д “Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно...”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж эзэмших, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын холбогдох заалттай нийцэхгүй байна.

##### **3.1.2 Эрсдэл:**

Холбогдох хууль, журам зөрчигдөх

### **3.1.3 Өгсөн зөвлөмж:**

Орон нутгийн салбарын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

### **3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Хүлээн зөвшөөрч байна. Дотоод хяналт сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллана.

## **3.2 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилт**

### **3.2.1 Илрүүлэлт:**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн байдлаар урьдчилж төлсөн тооцоо дансанд Хас кабель ХХК-д хамаарах 16.3 сая төгрөг байна. Уг урьдчилж төлсөн тооцоо 2009 оноос үүссэн тооцоо бөгөөд тухайн үед ажил хүлээлцэхдээ баримт бичиг дутуу бүрдүүлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар уг хөрөнгийг ашиглаж байгаа хэдий ч урьдчилж төлсөн тооцоо данснаас үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1-д “Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэж заасантай нийцэхгүй, мөн тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх журам”-д заасныг дагаж мөрдөөгүй байна.

### **3.2.2 Эрсдэл:**

Холбогдох хууль, журам зөрчигдөх

### **3.2.3 Өгсөн зөвлөмж:**

Үндсэн хөрөнгийг урьдчилж төлсөн тооцоо данснаас үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгэх, цаашид ийм зөрчил давтан гаргахгүй байх.

### **3.2.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа**

### **3.3.1 Илрүүлэлт:**

Бараа материалыг насжилтаар үзэхэд 2015 онд худалдан авсан 4.4 сая төгрөг, 2014 он болон 2014 оноос өмнө худалдан авсан 27.1 сая төгрөгийн насжилт өндөртэй бараа материал байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны онцлогоос хамаарч зайлшгүй байлгах бараа материалын нөөцийн хэмжээг тогтоосон зохицуулалт нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна.

Энэ нь НББОУС 2 - Бараа материалын өртөг болон цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар хэмжихийг шаарддаг гэсэн стандартыг мөрдөөгүй байна.

### **3.3.2 Эрсдэл:**

Холбогдох стандартыг мөрдөөгүй байх

### **3.3.3 Өгсөн зөвлөмж:**

Санхүү бүртгэлийн үйл ажиллагаандаа "НББОУС 2 Бараа материал"-ын стандартыг дагаж мөрдөх, компанийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч зайлшгүй байлгах бараа материалын нөөцийн хэмжээг тогтоож, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгах.

### **3.3.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

## **3.4 Зардлын данстай холбоотой асуудал**

### **3.4.1 Илрүүлэлт:**

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр даатгалын гэрээ, мөн 2018 оны 10 сарын 2-ны өдөр програмын лицензийн гэрээнүүд тус тус шинээр байгуулсан байна. Гэтэл хотын болон аймгийн салбаруудад 3.8 сая төгрөгийн тайлант онд ногдох урьдчилж төлсөн зардлыг буруу тооцоолж бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасан "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө" гэж заасантай нийцэхгүй байна.

### **3.4.2 Эрсдэл:**

Урьдчилж төлсөн зардлын тооцооллын алдаа гаргасан байх.

### **3.4.3 Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

### **3.4.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Хүлээн зөвшөөрч байна. Үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэнсий аудитын газарт 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.



#### 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

##### 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын үзүүлэлт	2017.12.31-ний үлдэгдэл	2018.12.31-ний үлдэгдэл
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	12,748,688,224.08	5,159,973,098.70
1.1.2	Дансны авлага	3,669,892,230.23	3,828,816,443.05
1.1.3	Татвар, НДШ - ийн авлага	159,361,711.52	183,209,365.02
1.1.4	Бусад авлага	284,931,815.96	260,243,346.20
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	3,000,000,000.00	3,000,000,000.00
1.1.6	Бараа материал	2,604,022,299.37	3,144,523,346.08
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,419,611,778.70	3,747,334,743.12
<b>1.1.11</b>	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>24,886,508,059.86</b>	<b>19,324,100,342.17</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	64,068,972,959.39	89,202,834,893.91
1.2.2	Биет бус хөрөнгө	114,249,748.92	37,425,454,461.20
1.2.3	Хойшлогдсон татварын хөрөнгө	266,782,567.59	283,658,196.14
1.2.4	Бусад эргэлтийн бус хөрөнгө	4,992,898,691.59	4,992,898,691.59
<b>1.2.10</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>69,442,903,967.49</b>	<b>131,904,846,242.84</b>
<b>1.3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>94,329,412,027.35</b>	<b>151,228,946,585.01</b>
<b>2</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч</b>		
<b>2.1</b>	<b>ӨР ТӨЛБӨР</b>		
2.1.1.1	Дансны өглөг	788,010,434.70	2,397,510,907.15
2.1.1.3	Татварын өр	0.00	0.00
2.1.1.4	НДШ-ийн өглөг	43,000.00	61,450,670.28
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	56,935,634.25	15,551,346.58
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	168,063,387.42	372,671,996.07
<b>2.1.1.13</b>	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>1,013,052,456.37</b>	<b>2,847,184,920.08</b>
2.1.2.1	Урт хугацаат зээл	46,745,952,902.63	44,620,755,057.75
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	3,333,236,961.95	2,904,293,207.50
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	-	446,000,000.00
<b>2.1.2.6</b>	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>50,079,189,864.58</b>	<b>47,971,048,265.25</b>
<b>2.2</b>	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>51,092,242,320.95</b>	<b>50,818,233,185.33</b>
2.3	Эзэмшигчдийн өмч	-	-
2.3.1	Өмч: - төрийн	137,551,494,711.54	137,551,494,711.54
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	413,738,403.33	16,291,526,517.35
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	1,347,724,159.68	41,204,833,121.41
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(96,075,787,568.15)	(94,637,140,950.62)
<b>2.3.11</b>	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>43,237,169,706.40</b>	<b>100,410,713,399.68</b>
<b>2.4</b>	<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>94,329,412,027.35</b>	<b>151,228,946,585.01</b>

**4.2 Аудит хийсэн Орлогын дэлгэрэнгүй тайлан**

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		Өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	33,946,308,076.22	40,040,380,296.04
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	28,550,613,470.69	32,881,533,331.90
<b>3</b>	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>5,395,694,605.53</b>	<b>7,158,846,964.14</b>
5	Хүүний орлого	1,425,950,682.41	679,792,306.21
8	Бусад орлого	28,476,085.98	57,960,433.35
9	Борлуулалт, маркетингийн зардал	299,988,181.91	337,051,524.59
10	Ерөнхий ба удирдлагын зардал	2,762,811,891.00	3,112,989,215.21
12	Бусад зардал	1,274,974,636.95	1,501,199,275.67
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(3,318,074.51)	(10,021,765.78)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	48,593,300.04	(23,742,666.81)
<b>18</b>	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>2,557,621,889.59</b>	<b>2,911,595,255.64</b>
19	Орлогын татварын зардал	402,351,331.44	862,211,531.68
	Хойшлогдсон татварын зардал	8,261,729.36	(445,166,757.95)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	2,147,008,828.79	2,494,550,481.91
<b>22</b>	<b>Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал</b>	<b>2,147,008,828.79</b>	<b>2,494,550,481.91</b>
<b>23</b>	<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>15,879,701,121.30</b>
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		15,879,701,121.30
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
<b>24</b>	<b>Орлогын нийт дүн</b>	<b>2,147,008,828.79</b>	<b>18,374,251,603.21</b>
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

### 4.3 Аудит хийсэн Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2016 оны 12-р сарын 31- ний үлдэгдэл</b>	<b>122,171,110,115.54</b>	<b>413,738,403.33</b>		<b>(97,473,015,609.45)</b>	<b>25,111,832,909.42</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт				18,573,100.92	18,573,100.92
Залруулсан үлдэгдэл	-	-	-	6,610,502.51	6,610,502.51
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	122,171,110,115.54	413,738,403.33		(97,466,405,106.94)	25,118,443,411.93
Бусад дэлгэрэнгүй орлого	-			2,147,008,828.79	2,147,008,828.79
Өмчид гарсан өөрчлөлт	-				
Зарласан ногдол ашиг	15,380,384,596.00		1,347,724,159.68		16,728,108,755.68
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-	-	756,391,290.00	756,391,290.00
<b>2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>413,738,403.33</b>	<b>1,347,724,159.68</b>	<b>(96,075,787,568.15)</b>	<b>43,237,169,706.40</b>
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	7,159,431.28	7,159,431.28
Залруулсан үлдэгдэл	137,551,494,711.54	413,738,403.33	1,347,724,159.68	(96,068,628,136.87)	43,244,329,137.68
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-			2,494,550,481.91	2,494,550,481.91
Бусад дэлгэрэнгүй орлого	-	15,879,701,121.30		(848,363,227.66)	15,031,337,893.64
Өмчид гарсан өөрчлөлт	-		39,857,108,961.73		39,857,108,961.73
Зарласан ногдол ашиг	-	-	-	(214,700,068.00)	(214,700,068.00)
Дахин үнэлгээний нэмэгдэл	-	(1,913,007.28)	-	-	(1,913,007.28)
<b>2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>137,551,494,711.54</b>	<b>16,291,526,517.35</b>	<b>41,204,833,121.41</b>	<b>(94,637,140,950.62)</b>	<b>100,410,713,399.68</b>

#### 4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	-	-
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>37,367,035,721.10</b>	<b>43,361,639,266.55</b>
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	37,202,242,288.00	43,220,172,238.10
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	4,903,359.00	14,562,002.00
	Бусад мөнгөн орлого	159,890,074.10	126,905,026.45
1.2	<b>Мөнгөн зарлага (-)</b>	<b>30,138,711,641.06</b>	<b>35,558,472,876.22</b>
	Ажиллагчдад төлсөн	10,582,840,947.15	11,426,900,217.69
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	2,749,755,062.26	3,182,884,980.92
	Бараа материал худалдан авахад төлсөн	1,401,580,544.71	1,954,782,746.27
	Ашиглалтын зардалд төлсөн	7,480,209,156.21	9,516,179,509.26
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	812,553,704.02	1,271,483,735.45
	Хүүний төлбөрт төлсөн	1,100,313,079.15	1,051,941,601.40
	Татварын байгууллагад төлсөн	4,768,834,119.38	5,745,332,090.06
	Даатгалын төлбөрт төлсөн	58,186,013.00	70,070,733.00
	Бусад мөнгөн зарлага	1,184,439,015.18	1,338,897,262.17
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>7,228,324,080.04</b>	<b>7,803,166,390.33</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	1,420,166,722.19	755,288,766.11
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	7,437,000.00	20,066,700.00
	Хүлээн авсан хүүний орлого	1,412,729,722.19	735,222,066.11
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>5,987,869,425.37</b>	<b>13,808,665,160.24</b>
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	5,877,869,425.37	13,806,165,160.24
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	110,000,000.00	2,500,000.00
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(4,567,702,703.18)</b>	<b>(13,053,376,394.13)</b>
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	6,076,893.52	12,915,935.50
	Бусад	6,076,893.52	12,915,935.50
3.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	2,894,895,433.40	2,351,421,057.08
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	2,125,197,844.88	2,125,197,844.88
	Төлсөн ногдол ашиг	756,391,290.00	214,700,068.00
	Бусад	13,306,298.52	11,523,144.20
3.3	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(2,888,818,539.88)</b>	<b>(2,338,505,121.58)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(228,197,163.02)</b>	<b>(7,588,715,125.38)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>12,976,885,387.10</b>	<b>12,748,688,224.08</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>12,748,688,224.08</b>	<b>5,159,973,098.70</b>

#### 4.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшингийн гүйцэтгэл

Тайлант хугацаа: 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2017 оны гүйцэтгэл	2018 он			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь	Биелэлт
1	Нийт орлого	төгрөг	35,465,483,216.01	40,251,447,693.96	40,825,653,955.70	101.4	574,206,261.7
2	Үүнээс: Үндсэн сүлжээний орлого	төгрөг	33,815,773,598.92	39,400,598,844.35	40,007,626,141.50	101.5	607,027,297.2
3	Нийт зардал	төгрөг	32,907,861,326.42	37,634,202,373.72	37,914,058,700.06	100.7	279,856,326.3
	Үүнээс: Удирдлагын зардал	төгрөг	883,394,000.00	859,340,000.00	858,695,000.00	99.9	(645,000.0)
4	Татварын өмнөх Ашиг алдагдал	төгрөг	2,557,621,889.59	2,617,245,320.24	2,911,595,255.64	111.2	294,349,935.4
5	Орлогын албан татвар	төгрөг	402,351,331.00	385,000,000.00	862,211,000.00	224.0	477,211,000.00
6	Цэвэр ашиг	төгрөг	2,147,008,000.00	2,232,245,320.24	2,494,550,000.00	111.8	262,304,679.8
7	Борлуулалтын 1 төг-т ногдох зардал	төгрөг	0.9	0.9	0.9	99.3	(0.0)
8	Нийт авлага	төгрөг	4,114,184,000.00	4,600,000,000.00	4,272,269,154.27	92.9	(327,730,845.7)
9	Нийт өр төлбөр	төгрөг	51,092,241,000	63,910,987,000	50,818,233,185	79.5	(13,092,753,815)
	Үүнээс: Богино хугацаат өглөг	төгрөг	1,013,052,000	669,823,000	2,847,184,000	425.1	2,177,361,000
10	Цалингийн сан	төгрөг	7,985,424,470.63	11,310,747,614.60	11,195,463,889.96	99.0	(115,283,724.6)
11	Нийт ажиллагсдын тоо	хүн	1,100	1,346	1,303	96.8	(43)
12	Нэг ажилтны дундаж цалин	төгрөг	781,569.00	700,269.17	716,005.62	102.25	15,736.45
13	Хөрөнгө оруулалт	төгрөг	11,514,452,000.00	10,956,500,000.00	10,523,907,000.00	96.1	(432,593,000.0)
14	Зээлийн төлбөр	төгрөг	2,125,197,000.00	2,125,197,000.00	2,125,197,000.00	100.0	-
15	Шилэн кабелийн гэмтэл	хувь	100.0	99.9	100.0	100.1	0.1
16	Шилэн кабелийн урсгал ашиглалтын %	хувь	85.0	85.0	85.0	100.0	-
17	100 цэгт ногдох гэмтэл /зэс кабель/	цэг	6.6	7.8	6.6	84.9	(1.2)
18	Төсвийн нийт төлбөр	төгрөг	8,274,980,000.00	8,508,000,000.00	9,142,917,138.98	107.5	634,917,139.0
	Үүнээс: Ногдол ашиг	төгрөг	756,391,000.00	892,898,128.10	214,700,068.00	24.0	(678,198,060.1)

## 5 Хавсралт

### 5.1 Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

<b>Огноо:</b> 2019/03/15	<b>Аудитын нэр:</b>	<i>Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны санхүүгийн тайлангийн аудит</i>	<b>Аудитын код:</b> САГ-2019/87/СТА-ТӨҮГ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК		<b>Сая төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл			Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Огноо	Дугаар	Албан тушаал	Овог нэр
А	3	4	5			9	10
1	Хөлсөөр ажиллах гэрээ байгуулж ажиллаж байсан гурван ажилтны цалингийн мэдээллийг нийгмийн даатгалын тайланд орхигдуулснаас Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсээс 2018 оны 0455 тоот “Шимтгэлийг нөхөн төлүүлж алданги ногдуулах тухай” улсын байцаагчийн актын дагуу 431.6 мянган төгрөгийн алданги тооцож, актын төлбөрийг 2018 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-иас барагдуулсан байна.	0.43	Төлбөрийн акт			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баярсайхан
2	Үндсэн хөрөнгийн тооллогоор 104.5 мянган төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгө дутагдсан бөгөөд тооллогын үр дүнг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй, эд хариуцагчаар дутагдсан хөрөнгийг төлүүлээгүй, холбогдох арга хэмжээ аваагүй байна.	0.10	Төлбөрийн акт			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баярсайхан
3	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн худалдан авалт болон гэрээний хэрэгжилтийг түүвэрлэн шалгахад тендер шалгаруулалтын онцгой журмыг зөрчиж Ихэр түрүү ХХК-тай 77,741.1 мянган төгрөг, Мэгүүн медиа ХХК-тай 32,360.0 мянган төгрөг, Арбел алтай ХХК болон Хатанбаатар ХХК-тай зураг	131.80	Албан шаардлага			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баярсайхан



	төсвийн зөвлөх үйлчилгээний гэрээг 21,698.4 мянган төгрөгийн тус тус гэрээнүүдийг шууд гэрээ байгуулсан байна.						
4	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Архангай болон Хөвсгөл аймгуудын салбарт: - Хөрөнгө данснаас хасах, актлахтай холбоотой баримтжуулалт хийгдээгүй 12,880.0 мянган төгрөгийн зөрчил, - Анхан шатны баримтжуулалтад гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарж баталгаажуулаагүй болон НБББББ-ийг баримтлаагүй 8,030.0 мянган төгрөгийн зөрчлүүд байна.	20.91	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
5	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2018 оны жилийн эцсийн байдлаар урьдчилж төлсөн тооцоо дансанд Хас кабель ХХК-д хамаарах 16,345.9 мянган төгрөг байна. Уг урьдчилж төлсөн тооцоо 2009 оноос үүссэн тооцоо бөгөөд тухайн үед ажил хүлээлцэхдээ баримт бичиг дутуу бүрдүүлсэн, гэрээ дүгнэсэн акт үйлдээгүй байна. 2018 оны 4 дүгээр улирлын байдлаар уг хөрөнгийг ашиглаж байгаа хэдий ч урьдчилж төлсөн тооцоо данснаас үндсэн хөрөнгө дансанд шилжүүлж бүртгээгүй байна.	16.34	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
6	Бараа материалыг насжилтаар үзэхэд 2015 онд худалдан авсан 4,442.5 мянган төгрөг, 2014 он болон 2014 оноос өмнө худалдан авсан 27,082.8 мянган төгрөгийн насжилт өндөртэй бараа материал байна. Байгууллагын үндсэн үйл ажиллагааны онцлогоос хамаарч зайлшгүй байлгах бараа материалын нөөцийг хэмжээ тогтоосон зохицуулалт НБББББ тусгагдаагүй байна	31.52	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан

7	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь 2018 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр даатгалын гэрээ, мөн 2018 оны 10 сарын 2-ны өдөр програмын лицензийн гэрээнүүд тус тус шинэчлэгдсэн байна. Гэтэл хотын болон аймгийн салбаруудад 3,779.2 мянган төгрөгийн тайлант онд ногдох урьдчилж төлсөн зардлыг буруу тооцоолж бүртгэсэн байна.	3.78	Зөвлөмж			Захирал Нягтлан бодогч	Ч.Золбаяр М.Баяр- сайхан
Нийт		204.90					



